

Д.Содномжамц¹✉

¹ ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Хадны зураг дахь хөлөгт тоглоомын дүрслэлүүд

Товчлол. Энэхүү өгүүлэлд Монгол нутгаас илэрч олдсон хадны зураг дахь хөлөгт тоглоомын дүрслэлүүдийг бусад газрын биед олдворуудтай харьцуулан үзэж зургийн утга агуулга, холбогдох он цагийн талаар зарим саналыг дэвшүүлжээ. Эдгээрийн дотроос Увс аймгийн Давст сумын Хороон орой уулын хадны зураг дахь дүрслэл нь Уйгурын үед холбогдох жиргээ хэмээх хөлөгт тоглоомуудтай ижилсэж байгаа бол Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Увс аймгийн Давст сумын Тэхтийн хөтөл, Завхан сумын Бувуугийн хадны зураг дахь дүрслэлүүд Ляо улсын үеийн бунхан болон дундад зууны үеийн Хархорум хотоос олдсон буга хэмээх хөлөгт тоглоомтой төстэй байна. Одоогийн байдлаар монгол нутгаас НТӨ I зуунаас НТ XIV зуун хүртлэх хугацаанд хамаарах олон тооны хөлөгт тоглоомын олдворууд илэрч олдсоноос гадна хадны зурагт бас сийлж үлдээсэн хэд хэдэн шинэ баримт байна.

Түлхүүр үг: Хадны зураг, Уйгурын хаант улс, хөлөгт тоглоом, жиргээ, уулын буга

D.Sodnomjamts¹✉

¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences, Building-1, Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Depictions of board games in petroglyphs

Summary. In this article, the representations of board games in the rock paintings found in Mongolia area compared with the findings from other places, and to offer some suggestions are made about the purpose and related chronology. Among them, the depictions in the petroglyphs of Khoroan Oroi mountain in Davst sum, Uvs province, are similar to the board games called “jirgee” related to the Uyghur period, while the depictions in Tevsh mountain in Bogd sum, Uvurkhangai province, Tehtien Khutel in Davst sum, Uvs province, and Buvuu rock paintings in Zavkhan sum, are similar to the Liao period tomb and It is similar to a board game called a “buga” found in the medieval city of Kharkhorum. At present, in the Mongolian territory, in the Xiongnu, Turkic, Uyghur, Khitan and Mongolian empires, many board games and piece have been found and there are also many evidences of these being carved into rock paintings for the purpose of playing games or some kind of symbol. The above facts are an important tool to show the extent of the intellectual culture of the ancient nomads who lived in Mongolia, and it also shows that we Mongolians are a people with a centuries old rich tradition of board games.

Keywords: Petroglyphs, Uighur khaganate, Board game, Jirgee (merels), Uulyн буга.

Удиртгал

Монгол нутагт хийсэн археологийн хайгуул, малтлага судалгааны явцад эртний нүүдэлчдийн оюуны соёлын түүхэн уламжлалыг илтгэн харуулахуйц хөлөгт тоглоомын холбогдол бүхий цөөнгүй олдвор илэрч олджээ. Эдгээрийн дотроос хамгийн эртнийх нь Архангай аймгийн Хайрхан сумын Гол мод-1 дурсгалын 1-р булшнаас гарсан Хүннүгийн үеийн модон дээр сийлсэн хөлөгт тоглоом орох бол үүнээс хойш одоог хүртлэх бүхий түүхэн цаг хугацаанд хамаарах хөлөгт тоглоом болон түүнийг тоглох төрөл бүрийн материалаар хийсэн хасаануудыг тойм байдлаар дурдаж болно [Ерөөл-Эрдэнэ 2007: 281, Эрдэнэбат нар. 2012: 114, Баярсайхан нар. 2017: 25]. Харин хадны зурагт сийлэгдсэн хөлөгт тоглоомын дүрслэлүүдийн талаар харьцангуй бага судлагдсан учир энэ удаад жиргээ болон уулын буга гэсэн хоёр өөр төрлийн тоглоомын үүрэг зориулалт, утга бэлгэдэл, холбогдох он цагийн талаар дэлгэрэнгүй өгүүлэхийг зорьсон болно.

Хороон орой уулын хадны зураг дахь хөлөгт тоглоомын дүрслэл

Хороон орой уулын хадны зургийн дурсгалт газар нь Увс аймгийн Давст сумын Хандгайт багийн нутагт оршдог. Энэхүү дурсгалт газрыг 2022 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид хадны зургийн хайгуул судалгааны ажлын явцад анх илрүүлж, бүртгэн баримтжуулсан юм [Батболд нар. 2022]. Баруун Тагнын нурууны салбар уулсын нэг болох Хороон орой хэмээх уул нь Монгол улсын хилийн бүсэд орших бөгөөд түүний баруун талын уужим хөндийг Хөдний хөдөө, Хөх сайрын хөтөл хэмээн нэрлэх бол зүүн талын өндөр уулсыг Бургаст гэнэ. Хороон орой уул нь орой болон энгэр хэсгээрээ элсэн чулуун тогтоц бүхий хавтгай ханан хадтай бөгөөд уулын урд энгэр, бэлийн хаднуудад ан амьтан, аж ахуйн сэдэв зонхилсон олон тооны хадны зургийн дүрслэлтэй. Эдгээр хадны зургуудын дотроос хөлөгт тоглоомын дүрслэл байж болохуйц нэгэн зураг нэлээд өвөрмөц юм.

Энэхүү дүрсийг Хороон орой уулын урд энгэрт орших 75 x 70 см хэмжээтэй хавтгай хадны тэгш гадаргуу дээр сийлсэн ба дээрх дүрслэлүүдийг нь дор дэлгэрэнгүй тайлбарлаж үзье. Голоороо хагарч цуурсан байдалтай орших нэгэн хадны баруун талын гадаргуугийн төв хэсэгт дотор дотроо орсон гурван ширхэг дөрвөлжин дүрсийг хөндлөн, ташуу зураасаар өнцөг болон талуудыг хооронд нь холбож хийсэн ерөнхий зохиомжтой ба дүрслэлийн аргын хувьд гадна хүрээг хөвөөлдөн хонхойлгон цохих аргаар хөлөгт тоглоомын хөлгийг сийлжээ. Хөлгийн хэмжээ 25 x 18 см, босоо болон ташуу зураасны өргөн 0,7-

1,5 см, цохилтын талбайн гүн ойролцоогоор 0,2 см юм. Мөн түүнчлэн хөлөгт тоглоомын дүрсийг тойрсон зурагнуудын сийлсэн арга барил, сэдэв зохиомжоос харахад нэгэн цаг үед зурсан байх боломжтой байна. Хөлөгний дээд талд хоёр гараа алдлан зогсож буй нэг хүн, түүний зүүн хажууд зургийн алслал гарган жижиг хэмжээтэйгээр зурсан өөр нэг хүн, эдгээрийн баруун дээд талд хоёр бөхтэй тэмээг бурантаглан жолоог дээш шилний хэсэгт сойсон байдлаар дүрслэн харуулжээ. Тэмээний доод талд амьтны их бие болон хөлийг зурж толгойг дутуу сийлжээ. Хөлөгний зүүн талд ямар нэг дүрслэл байхгүй ба доод талд харин дээрхтэй ижил гараа алдлан зогсож буй 4 хүн, нэг янгир, баруун захад нохойтой төстэй урт сүүлтэй амьтныг тус тус дүрсэлжээ. Хөлөгний дүрсний баруун талд мөн дутуу сийлж орхисон үл танигдах дүрслэлүүд байх ба баруун захад дотроо нэмэх тэмдэг маягийн дүрстэй 2 ширхэг дөрвөлжин дүрсийг хооронд нь зураасаар холбож эдгээрийн дээд болон доод талд тусад нь шулуун зураас зурсан байна. (Зураг 1). Дээр дурдсан дүрслэлүүд дотроос тоглоомын хөлгийн дээд болон доод талд буй хүмүүсийн дунд гараа алдлан зогсож буй 2 хүний бүсэлхий орчимд ямар нэг зүйлийг зүүсэн болохыг хөндлөн зураасаар илэрхийлжээ. Үүнийг бүснээс зүүсэн сэлэм болов уу хэмээн таамаглаж байна.

Дээрх дүрслэлүүдийн сэдэв зохиомж хийгээд зургийн байрлалаас харахад төв хэсэгт хөлөгт тоглоомын хөлгийг онцгойлгон томоор дүрсэлж, дээд болон доод талд хүмүүсийг зогсоо байдлаар зурсан байгаа нь ямар нэг үйл явдлыг тойм байдлаар дүрслэн харуулахыг хичээсэн нь илт байна. Бидний таамаглаж буйгаар хөлгийн доод хэсэг дэх дөрвөн хүн нь гол хүмүүс буюу талбайн эзэд бол дээд талд буй тэмээнийхээ жолоог сойж, гараа алдлан бүсэндээ сэлэм агссан хүн нь гаднаас ирсэн өрсөлдөгч талынх бололтой. Хэдийгээр энэхүү дүрсийг тоглох боломжгүй налуу хавтгайд сийлсэн хэдий ч дүрслэлийн утга агуулга, ерөнхий зохиомжийн хувьд хөлөгт тоглоом тоглож буй дүр байдлыг харуулж зурсан зураг хэмээн үзэж байна.

Хороон оройн хадны зурагт сийлсэн энэхүү хөлөгт тоглоомыг “жиргээ” хэмээн нэрлэдэг бөгөөд эртнээс нааш монголчуудын дунд өргөн тархсан оюуны соёлын чухал өв мөн болохыг археологийн биет олдворууд гэрчлэн харуулдаг. Жиргээ хэмээх энэхүү хөлөгт тоглоом нь дэлхийн олон оронд янз бүрийн цаг хугацааны давтамжтайгаар өргөн тархжээ. Уг тоглоомын өрнө зүгт тархсан хувилбарын нэрийг судлаачид тайлбарлахдаа, Morris гэдэг нь латин хэлний merellus хэмээх үгээс гаралтай бөгөөд тоглоомын хасаа, мөн эсрэг тал гэсэн утгатай гэжээ [Содномжамц / Эрдэнэбат 2010 : 99]. Энэхүү

тоглоом анх эртний соёлт Египет оронд үүсэж, улмаар Африк, Европ, Азийн олон оронд түгэн дэлгэрсэн, тэгэхдээ тухайн газар нутгийнхаа улс түмний соёлын онцлогоос хамаарч өөр өөр нэртэй болсон түүхтэй. Тухайлбал, Өмнөд Африкт Mora-baraba, Энэтхэгт Naukhadi, Францад Jeu de Moulin, Италид Mulino, Германд Muehlespiel, Орост мельница, дундад зууны Ром, Византын үед Nine Men's Morris, Сомалийн арлуудад Shax [Berger 2004: 16] хятадад Lianqi (连棋) гэж нэрлэгдэж байсан ажээ. Энэхүү тоглоомын хөлгийн харилцан адилгүй цаг үед бүтээгдсэн дүрс тэмдгүүд дээрх олон газар орны өөр өөр дурсгалт газраас хадны сүг зураг, сүмийн хана туурга, торгон нэхмэлийн зураг, булшны чулуу, сандал ширээ, хөлөг онгоцны тавцан зэрэгт сийлсэн байдлаар, мөн жинхэнэ тоглоомын хөлөг байдлаар ч эртний хот суурин ба булш оршуулгын аль алианаас нь олдож байжээ.

Монгол нутагт хийсэн археологийн хайгуул малтлага судалгааны явцад энэхүү хөлөгт тоглоомын биет олдворууд цөөнгүй тоогоор олдож тэдгээрийн талаар судалгааны бүтээлүүд хэвлэгдэн гарсан билээ. Анх 2009-2010 онд Архангай аймгийн Хотонт сумын Уйгурын хаант улсын нийслэл Хар балгасын цайзат их хэрмийн доторх суваргын дэргэдэх хоёр шороон овгорын өмнө талын (зүүн барилга) байгууламжаас хоёр ширхэг, мөн хойд талын барилгын (баруун барилга) нүүрэн талаас нэг ширхэг олджээ [Эрдэнэбат нар. 2012: 114-115] (Зураг 2). Үүнээс гадна Хотонт сумын Өвөрхавцалын амны 5-р дөрвөлжингийн малтлагаас нэг ширхэг [Одбаатар 2013: 166] (Зураг 3 а), 2015 онд Хар балгас хотын НВ-4 малтлагын талбайгаас нэг ширхэг, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Их арцатын амнаас нэг ширхэг [Гомбожав, Батболд 2019: 33] (Зураг 3 б) тус тус илэрчээ. Эдгээрийг бүгд хөх саарал өнгийн тоосгон дээр тоглоомын хөлгийг хурц үзүүртэй багажаар сийлж зурсан зохиомжтой ба одоогийн байдлаар жиргээ хэмээх тоглоомын хөлөг биет байдлаар нийт 6 ширхэг олдсон байна. Харин тоглоомын хөлөг болгон ашиглах боломжгүй хэдий ч хадны зураг болон өөр эд зүйлс дээр хөлгийн дүрсийг сийлсэн байгаа нь нарийн утга бэлгэдэл агуулсан тамга тэмдэг мэтээр ойлгогдож байсныг үгүйсгэх аргагүй. Үүний нэг жишээ нь Хар балгас хотын малтлагаас олдсон бог малын шагайн дээрх хөлөгт тоглоомын дүрслэл юм (Зураг 2 д).

Хороон оройн хадны зурагт буй дээрх дүрслэлүүдийг бусад газраас олдсон хөлөгт тоглоом тоглож буй үйл явдлыг харуулсан номын чимэглэл зураг болон уран зургуудтай харьцуулан үзэхэд ихэвчлэн гол хэсэгт тоглоомын хөлөг, хажуу талд нь тоглож буй 2 хүн болон тэднийг хамгаалагч эсвэл дэмжигч хүмүүсийг дүрслэн

харуулах явдал аль ч түүхэн хугацаанд түгээмэл байжээ. Тухайлбал НТ XII зууны үед холбогдох Испанийн Мадрид хотын ойролцоох Эл Эскориал сүмээс олдсон “Тоглоомын ном (Libro de los Juegos)” хэмээх нэгэн бүтээлийн чимэглэл зурагт бидний өгүүлэн буй жиргээ хэмээх хөлөгт тоглоомыг тоглож буй хоёр хүн, тэдний ар талд жад барин зогсож буй хамгаалагч бололтой өөр хоёр хүнийг тус тус дүрслэн харуулсан байна (Зураг 4 б). Үүнээс гадна Мин улсын үед холбогдох “Зуун хүүгийн тоглож буй зураг (百子图)” хэмээх уран зурагт янз бүрийн тоглоом наадгайгаар тоглож хүүхдүүдийн дотроос жиргээ тоглоом тоглож буй дөрвөн хүүгийн дүрслэл ихээхэн сонирхолтой [Song Wu, Pailine Sebilaud 2020: 49] (Зураг 5). Энд жиргээ тоглоомын хөлгийн хажууд нэг хүү хасаагаа хөлөг дээр байршуулан нүүж байгаа бол өрсөлдөгч нөгөө талын хүүхэд хэрхэн нүүх талаараа бодлогошрон сууна. Харин цаад талд нь өөр хоёр хүүхэд тэднийг хэрхэн тоглож буйг баясан харж байгаа байдлаар зуржээ. Дээрх жишээнүүдээс үзэхэд Хороон орой уулын хадны зураг дахь тоглоомын хөлөг болон түүнийг тойрон хүрээлж зурсан хүн, амьтдын дүрслэлүүд нь бүхэлдээ нэг утга санаа бүхий үйл явдлыг тоймлон харуулсан зураг мөн гэж үзэх үндэслэлийг төрүүлж байна.

Өгүүлэн буй сэдвийн хүрээнд холбогдох судалгааны материалуудаас шүүж үзэхэд хөрш зэргэлдээх бүс нутгийн хадны зурагт мөн адил жиргээ тоглоомын хөлгийг сийлж үлдээсэн баримтуудыг дурдаж болно. Тухайлбал, ОХУ-ын Дээд Кубан мөрний эрэгт байрлах Кайфар хэмээх Христийн шашны сүмийн ойролцоох нэгэн хаданд жиргээ тоглоомын хэд хэдэн хөлөг сийлсэн ба он цагийн хувьд НТ X-XIII зууны үед хамаарах ажээ [Arzhantseva 2002: 24]. Мөн Хятадын Хөхнуур мужийн Юүшүгийн Төвөдийн өөртөө засах жоугийн Мумо сандуо (木莫桑朵) хэмээх газарт орших нэгэн хавтгай хаданд гурван өөр төрлийн хөлөгт тоглоомыг дүрсэлжээ [Nimajiangcai 2016: 336, CGM]. Хавтгай хадан дээрх дүрслэлүүдээс харахад баруун захад жиргээ, дунд нь мягман, зүүн захад буга жиргээ гэсэн хөлөгт тоглоомууд байна. Мөн эндээс ойролцоо орших Дунгуо (东果) хэмээх газарт орших хавтгай чулуунд мягман шатар болон жиргээ тоглоомын хөлгийг тус тус дүрсэлжээ. Үүнээс гадна Жиангсу мужийн Лиан Юнган хотын Жанжин уулын хадны зураг дахь 2 ширхэг хөлөг, Юүннан мужийн Илиан суурингийн Жиүсиан дахь барилгын чулуун хананы суурь хэсэгт нэг ширхэг [Deng Qiyaoyao 2004: 172] зэргийг тус тус дурдаж болно.

Хороон орой уулын хадны зурагт дүрсэлсэн жиргээ хэмээх хөлөгт тоглоомтой төстэй дүрслэлүүд дэлхийн олон газарт хийгдсэн

археологийн малтлага судалгааны явцад биет байдлаар олдсоноос гадна хадны зураг, номын чимэглэл зураг, уран зурагт мөн тусгалаа олжээ. Эдгээрийг үүсэл гарал болон дүрслэлийн ялгаатай байдалд тулгуурлан үндсэн хоёр төрөлд хуваан үздэг. 1-р төрлийн хөлөгт тоглоомыг өрнөдийн орнуудад “Nine Men’s Morris”, 2-р төрлийн тоглоомыг “Twelve Men’s Morris” хэмээн нэрлэдэг бөгөөд бүхэлдээ жиргээ тоглоомын төрлүүд юм. Гол ялгаа нь 9 болон 12 хасаагаар тоглодогт оршино.

1-р төрлийн тоглоомтой төстэй хамгийн эртний дүрслэл Египетэд НТӨ 1400-1300 оны үеийн Курна хэмээх сүмийн хананд байдаг талаар судлаачид өөрийн бүтээлдээ олонтоо дурдсан байдаг [Bell 1960: 93, Murray 1978: 18-19, 44]. Энэ төрлийн тоглоомын үүсэл гарвацийн талаарх баримтуудыг бид өмнөх өгүүлэлдээ хангалттай дурдсан [Эрдэнэбат нар. 2012: 114-133] учир энд товч байдлаар авч үзэв. Жиргээ тоглоом олдсон дээрх баримтуудаас үзэхэд анх Африк тивд эрт цагт үүсэж, тэндээсээ Дундад Азиар дамжин Европ болон Төв Ази руу түгэн дэлгэрчээ. Харин 2-р төрлийн хөлөгт тоглоомын олдворуудын дотроос биет байдлаар олдсон хамгийн эртнийх нь НТ VIII-IX зууны үед холбогдох Уйгурын үеийн Хар балгасны хэрэглэгдэхүүнүүд орж байна. Үүнээс хожуу үед буюу Бохай, Ляо, Сүн, Алтан, Юань улсын үед хамаарах олон тооны хөлөгт тоглоомууд одоогийн ОХУ-ын Алс дорнод болон БНХАУ-ын умард бүс нутагт өргөн тархжээ.

Хороон орой уулын жиргээ хэмээх хөлөгт тоглоомын дүрслэлээс гадна он цагийн хувьд арай хожуу үед хамаарах өөр төрлийн тоглоомууд Тэвш уул, Тэхтийн хөтөл, Булуу зэрэг газрын хадны зурагт байна.

Тэвш уулын хадны зураг дахь хөлөгт тоглоомын дүрслэл

Тэвш уулын хадны зургийн дурсгалт газар Өвөрхангай аймгийн Богд сумын төвөөс зүүн урагш 14 км зайд Арц Богдын нурууны хойд талд оршдог. Энэхүү дурсгалт газрыг 1948-1949 онд С.В.Киселев, Х.Пэрлээ нарын судлаачид анх илрүүлж судалгааны эргэлтэд оруулсан бөгөөд 1980 онд А.П.Окладников Тэвш уулын хадны зургийн тухай өгүүлсэн томоохон бүтээлийг хэвлүүлсэн байдаг [Окладников 1980: 26, табл.51-1]. Тэрхүү бүтээлд ан амьтан болон хүмүүсийн ахуй байдлыг харуулсан олон тооны хадны зургуудын талаар товч тайлбар, гар зургийн хамт нийтлүүлсний дотроос энд онцлон өгүүлж буй хөлөгт тоглоомын дүрслэл бидний сонирхлыг татсан юм.

Тус хөлөгт тоглоомын дүрсийг 2022 онд Монголын говь дахь хадны зургийн цогцолборыг

дэлхийн соёлын өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх урьдчилсан судалгааны ажлын хүрээнд Тэвш уулын хадны зургийн дурсгалт газарт хийсэн баримтжуулалтын ажлын явцад гар зураг болон товч тодорхойлолтыг хийсэн юм. Энэхүү зураг нь Тэвш уулын зүүн урд хэсэгт орших нэгэн хадны дээш харсан тэгш гадаргууд сийлж зурсан ба ойр орчимд хүрлийн хожуу үед хамаарах ан амьтны сэдэвт зураг олон бий. Хөлөгт тоглоомын зураг нь дүрслэлийн аргын хувьд бусад хадны зургуудаас эрс ялгаатай ба нэлээд хожуу үед сийлэгдсэн бололтой. Зургийн ерөнхий зохиомжийн хувьд нийт дөрвөн ширхэг жижиг тэгш дөрвөлжингөөс бүрдсэн нэг том дөрвөлжин дүрс ба тэдгээрийг дотор нь талууд болон өнцөг булангуудыг хөндлөн, ташуу зураасаар холбож, хоёр хажууд нь нэмж босоо дөрвөлжин дүрс залгагдсан бүтэцтэй. Хадан дээр хөлгийг зурахдаа дөрвөлжин дүрсүүдийг хурц үзүүртэй багажаар хичээнгүйлэн хооронд нь холбон нарийн гаргасан ба зарим газарт давхарлан зурсан нь мэдэгдэнэ (Зураг 7 а). Үүнтэй ижилхэн хөлөгт тоглоомын дүрслэл Увс аймгийн Давст сумын Тэхтийн хөтөл болон Завхан сумын Булуугийн хадны зурагт тус тус сийлэгдсэн байна (Зураг 7. б, с, d). Харин хөлөгт тоглоомын биед олдвор 1948-1949 онд Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дахь эртний Хархорум хотын малтлагын явцад хөх өнгийн тоосгон дээр сийлсэн хагархай хэсэг илэрч олдсоныг нэрт эрдэмтэн Х.Пэрлээ сэргээн зурж эртний Монголын “буга” хэмээх хөлөгт тоглоом хэмээн нийтлүүлсэн түүхтэй [Евтюхова 1965: 295, Рис.155-6] (Зураг 8 а, б).

Тэвш уулын хадны зурагт сийлсэн энэхүү хөлөгт тоглоомыг монголчууд “Уулын буга” хэмээн нэрлэдэг байжээ. Ерөнхийдөө энэ тоглоом нь дотроо гурван төрөлтэй ба уулын буга, уул талын буга, талын буга гэдэг [Намжилдорж 1963: 124-133]. Уулын буга тоглоом нь гучин гурван буудалтай ба хоёр бугын эсрэг 20-22 ширхэг хүүгээр тоглох бөгөөд буудал бүрийн нэрийг “толгой, дух, чих, баклуур, мөр, шор, зүрх, товчлуур, суга ба сөвөө, бөөр, баян буудал, гол, хушуу” зэрэг малын эд эрхтний нэрээр нэрлэж тоглодог уламжлалтай [Намжилдорж 1966: 522]. Харин Хархорум хотын малтлагаас олдсон тоосгоны хагархай дээрх хөлгийн дүрсээс харахад голын дөрвөлжин дүрсний нэг булан болон захын босоо гурвалжингийн зөвхөн нэг хэсэг нь л мэдэгдэж байгаа учир чухам аль төрлийн буга тоглоом болохыг шууд тогтоох боломжгүй байна.

Харин Увс аймгийн Давст сумын Тэхтийн хөтлийн хадны зурагт сийлсэн хөлөг нь Тэвш уулын уулын буга тоглоомын хөлөгтэй төстэй боловч хажуу талын чих маягийн босоо гурвалжин дүрс байхгүйгээрээ бага зэргийн ялгаатай (Зураг 8

б). Тэгвэл энэ төрлийн тоглоомыг Н.Намжилдорж гуай “тугал буга” гэсэн нэрээр нийтэлсэн байна. Тугал бугын хөлөг 29 буудалтай ба нэг тугал бугыг барих гэж 12 хүүхэд хөөж тоглодог дүрэмтэй ажээ [Намжилдорж 1963: 140].

Одоогоор мэдэгдэж буй буга тоглоомын төрлийн хамгийн эртний олдвор 1980 онд Хятадын Ляонин мужийн Жианчан дахь Ляо улсын (907-1125) үеийн бунхны малтлагаас 24,5 см урт, 16-25 см өргөн 8,5 см-ын зузаантай дөрвөлжин хэлбэрийн чулуун дээр сийлсэн хөлөг олдсон байна (Зураг 9 а). Хөлгөн дээр Хятан бичээс бичсэн байжээ [Feng Yongqian, Deng Baoxue 1983: 68]. Энэхүү тоглоом нь хоёр хажуугийн чих маягийн босоо дөрвөлжин дүрс байхгүй боловч бусад дүрслэлийн хувьд монгол нутгаас олдсон буга тоглоомын хөлгүүдтэй төстэй ба магадгүй энэ төрлийн тоглоомын анхны хувилбаруудын нэг байсныг үгүйсгэхгүй юм. Харин энэ тоглоомыг хожмын монголчууд дөрвөн буга хэмээн нэрлэдэг [Намжилдорж 1963: 140]. Үүнтэй ижил хөлөгт тоглоомын хөлөг ӨМӨЗО-ны Тунляо хотын Хуолинхэ уурхайн орчим дахь Алтан улсын үеийн хотын тууриас жиргээ тоглоомын хөлгийн хамт олдсон байна [Shao Qinglong 1984: 168] (Зураг 9 б). Мөн Баяннуур хотын Урад хошууны Хайрхан [Tong Yongsheng 2010: 28], Юүннан мужийн Юүшү уул болон Хэнан мужийн Жүси уулын хадны зурагт [He-nan 2014: 91] буга тоглоомын хөлөг дүрсэлжээ (Зураг 9 с, d, e). Үүнээс гадна Өмнөд Энэтхэгийн Карнатака дахь Вижаянагара хэмээх эртний хотын ойролцоох хадан дээр олон зуун хөлөгт тоглоом дүрсэлснийг судлаачид НТ 1350-1565 оны үед холбогдоно хэмээн үзжээ [Elke Rogersdotter 2010: 288] (Зураг 9 f). Эдгээр тоглоомын дүрслэл дотор буга тоглоомын хөлөг хэд хэд байна.

Дээрхээс үзвэл уулын буга хэмээх хөлөгт тоглоом нь олон зууны туршид дэлхийн бусад газруудад түгэн дэлгэрэхдээ тухайн ард түмний ахуй амьдралын онцлогийг өөртөө шингээн уламжлагдан хөгжиж иржээ. Дорно дахины ном судруудад хөлөгт тоглоомоор тоглоно гэдэг бол нэг ёсны тулалдах урлаг юм хэмээн тодорхойлсон байдаг. Монгол ардын зүйр цэцэн үг, үлгэр, оньсого тааварт ч гэсэн шатар тоглохыг “усгүй талд хүнсгүй цэрэг цусгүй байлдана” “дөрвөлжин дээр төр булаалдана, төрсөн бие нь ухаан булаалдана” гэж хэлдэг [Өлзийхутаг 1989: 131-133]. Учир нь тоглогч хүн түрүүлж хэдэн нүүдлийн цаадах аюулыг олж харах, эсрэг этгээдийн санааг урьдчилан таних, отох улмаар хөлгийн тавцанг эзлэх зэрэг цэвэр стратеги учир тоглоомд олсон мэдлэгээ дээр үеийн хүмүүс дайн тулаанд өргөн ашиглаж байжээ. Тийм ч учраас дорно дахины улс орнуудад хөлөгт тоглоомын авьяас чадварыг эрхэмлэн үзэж, бичиг цэргийн түшмэдийн мэдвэл зохих гол шалгуурын нэг болгож байсан билээ.

Хадны зургийн холбогдох он цаг ба товч дүгнэлт

Хороон орой уулын хадны зурагт сийлсэн хөлөгт тоглоомын дүрслэлтэй ижил хэрэглэгдэхүүн Орхоны хөндийд орших Уйгурын хаант улсын үед холбогдох хот суурин, булш оршуулгын дурсгалаас хэд хэдэн тоогоор илэрч олдсон бөгөөд монголчууд жиргээ хэмээн нэрлэж байжээ. Мөн хөлөгт тоглоомын дүрслэлийн эргэн тойронд зурагдсан байгаа бусад хүн болон амьтны зургуудыг бид нэг цаг хугацаанд сийлсэн тоглоом тоглож буй хүмүүсийн дүр байдлыг илтгэн харуулсан зохиомж хэмээн үзэв. Эдгээрийн дотроос тэмээ, нохой зэрэг амьтдын их биеийг хөвөөлдөн цохих аргаар дүрсэлж, гэдэс болон хөлийг зурахдаа дээд хэсгийн дүрслэлтэй холболгүй тусад нь гаргасан байгаа нь Түрэгийн үеийн зарим зургуудтай ижил юм. Тухайлбал Ховд аймгийн Манхан сумын Жаргалант хайрхан уулнаас олдсон хөгжмийн зэмсгийн доод хэсэгт зурсан амьтдын зурагтай [Төрбат нар. 2008: 279] төстэй байна. Тиймээс дээрх харьцуулалтууд дээр үндэслэн Хороон орой уулын хадны зураг дахь эдгээр дүрслэлүүдийг Түрэг, Уйгурын үед буюу НТ VI-IX зуунд холбогдуулан авч үзэх саналтай байна.

Уулын буга хэмээх хөлөгт тоглоомын дүрслэл монгол нутгаас нийт 5 ширхэг илэрсний дотор хамгийн эртнийх нь дундад зууны үеийн Хархорум хотын тууриас олдсон бол Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Увс аймгийн Давст сумын Тэхтийн хөтөл, Завхан сумын Бувуу зэрэг бусад газруудын хөлгийн дүрслэлүүд хамгийн эртдээ НТ XIII-XV зуун эсвэл түүнээс хойш үед холбогдох бололтой. Бувуугийн хадны зурагт өмнөх үед цохиж сийлсэн янгирын дүрс дээр хурц үзүүртэй багажаар хөлгийг нэмж давхарлан зурсан байгаа нь хожуу үед холбогдохыг давхар илтгэнэ.


Ном зүй

Arzhantseva 2002 – Arzhantseva, I. The Christianization of North Caucasus (Religious Dualism among the Alans) in: Die Christianisierung des Kaukasus, (Refe-rate des Wiener Symposium), Wien., 2002.


Батболд нар. 2022 – Батболд, Н., Содномжамц, Д., Буян-Орших, Б. Монгол-Германы хамтарсан MAPSS төслийн хүрээнд Увс аймгийн нутагт хийсэн хадны зургийн судалгааны ажлын тайлан. УБ, 2022.

Баярсайхан нар. 2017 – Баярсайхан, Ж., Түвшинжаргал, Т., Баяндэлгэр, Ч., Мөнх, Л. Ховд аймгийн Мянгад сумын нутаг “Урд улаан үнээт” уулын дурсгал. Хадан гэрийн өв соёл үзэсгэлэнгийн каталог, УБ, 2017.


- Bell 1960** - Board and Table Games from Many Civilizations. Oxford university press, New York., 1960.
- Berger 2004** – Berger, F. From Circle and Square to the Image of the World: A Possible Interpretation for some Petroglyphs of Merels Boards. // Rock Art Research. Vol. 21, No.1. 2004.
- Гомбожав, Батболд 2019** – Гомбожав, Н., Батболд, С. Их Арцатын аманд шинээр бүртгэсэн дурсгалууд. Нүүдэлчдийн өв судлал. Том-XX-II, Fasc-3, УБ. 2019.
- Евтюхова 1965** – Евтюхова, Л.А. Изделие различных ремесел из Кара-Корума. Древнемонгольские города. М, 1965.
- Elke Rogersdotter 2010** – Tracing a Neglected Heritage of Play: Report from a field documentation of engraved game board at the ancient site of Vijayanagara, Karnataka, South India (c. AD 1350-1565). South Asian Archaeology 2007, Vol II. 2010.
- Елихина 2018** – Елихина, Ю.И. Эрмитаж дахь Хархорум хотын өв С.В.Киселёвын шинжилгээний анги: 1948-1949 он. УБ, 2018.
- Ерөөл-Эрдэнэ 2007** – Ерөөл-Эрдэнэ, Ч. Хүннү булшнаас олдсон хөлөгт тоглоом (Гол модны хүннү булшны хэрэглэгдэхүүнээр). – Studia Archaeologica. Tom. (IV) XXIV, Fasc. 19, УБ, 2007.
- Одбаатар 2013** – Одбаатар, Ц. Монгол нутаг дахь эртний Уйгурын бунхант булшны судалгаа. Докторын зэрэг горилох нэгэн сэдэвт зохиол. УБ, 2013.
- Окладников 1980** – Окладников, А.П. Петроглифы Центральной Азии. Ховд сомон /гора Тэбш/. Ленинград., , 1980.
- Өлзийхутаг 1989** – Өлзийхутаг, Ц. Түмэн оньсого 2. УБ, 1989.
- Намжилдорж 1963** – Намжилдорж, Н. Монголын хөлөгт тоглоом (тэргүүн дэвтэр). УБ, 1963.
- Намжилдорж 1966** – Намжилдорж, Н. Монголын хөлөгт тоглоом (дэд дэвтэр). УБ, 1966.
- Murray 1978** – Murray H.J.R., A history of board-games other than chess. Haker Art Books, New York., 1978.
- Содномжамц, Эрдэнэбат 2010** – Содномжамц Д., Эрдэнэбат У. Уйгурын нийслэл Хар Балгаснаас олдсон нэгэн шинэ олдворын тухай. Удирдсан багш, доктор У. Эрдэнэбат. – МУИС-ийн оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл. №13 (21), УБ. 2010.
- Song Wu, Pailine Sebillaud 2020** – Song Wu., Pailine Sebillaud. Research on the merels game in medieval China. Asian Archaeology (2020) 4.
- Төрбат нар. 2008** – Төрбат, Ц., Батсүх, Д., Батбаяр, Т., Баярхүү, Н., Идэрхангай, Т. Монгол Алтайгаас илэрсэн хадны оршуулгууд. – Studia Archaeologica. Tom. (VI) XXVI, Fasc. 14, УБ, 2008.
- Эрдэнэбат нар. 2012** – Эрдэнэбат, У., Батбаяр, Т., Содномжамц, Д. Хар балгаснаас олдсон хөлөгт тоглоом. – Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol. 7, № 1 (378). УБ, 2012.
- Deng Qiyao 2004 – 邓启耀 《云南岩画艺术》 云南美术出版社2004年。
- Nimajiangcai 2016 – 尼玛江才《玉树岩画》青海人民出版社, 2016年。
- Henan 2014 – 河南新郑黄帝故里文化研究会, 中央民族大学民族学与社会学院《具茨山岩画调查报告》光明日报出版社, 北京., 2014.
- Shao Qinglong 1984 – 邵清隆《内蒙古霍林河矿区金代界壕边堡发掘报告》考古1984年02期。
- Feng Yongqian, Deng Baoxue 1983 – 冯永谦, 邓宝学《辽宁建昌普查中发现的重要文物》文物1983年09期。
- Tong Yongsheng 2010 – 童永生《中国岩画中的原始体育文化考释》成都体育学院学报, 2010(10).



Зураг 1. Хороон орой уулын хадны зураг дахь хөлөгт тоглоомын дүрслэл




Зураг 2. Уйгурын нийслэл Хар балгас хотоос олдсон хөлөгт тоглоомууд. a, b, c. 2009-2010 онд олдсон жиргээ хэмээх хөлөгт тоглоом, d. Шагайн дээр дүрсэлсэн хөлөг [Гар зургийг Т.Батбаяр, 2012]




Зураг 3. Уйгурын үед хамаарах бусад хөлөгт тоглоом а. Архангай, Хотонт, Өвөрхавцалын амны 5-р дөрвөлжин в. Өвөрхангай, Хархорин, Их Арцатын ам




Зураг 4. а. Дэлхийд тархсан үндсэн хоёр хэлбэр; b. Nine Men's Morris (Испани, XII зуун) тоглож буй зураг (Libro de los juegos, San Lorenzo de El Escorial, Madrid)




Зураг 5. Мин улсын үед хамаарах “Зуун хүүхэд наадаж буй зураг” [Song Wu, Pailine Sebillaud 2020]




Зураг 6. Хадны зурагт дүрслэгдсэн хөлөгт тоглоомын дүрслэлүүд. а. ОХУ, Кайфар сүм [Arzhantseva 2002], б. БНХАУ, Юүниан муж, Илиан суурин [Deng Qiyaо 2004], с. Хөхнуур муж, Юүшү уул [Nimajiangcai 2016], д. Жиансу муж, Жанжин уул (зургийг С.Тэргүүнбаяр)



Зураг 7. Монгол нутгаас олдсон хадны зураг дахь буга тоглоомын хөлөгний дүрслэлүүд. а. Өвөрхангай, Богд, Тэвш уул, б. Увс, Давст, Тэхтийн хөтөл, с, д. Увс, Завхан, Буууу уул



Зураг 8. а. Хархорум хотын малтлагаас олдсон тоглоомын хөлөг [Елихина 2018], б. Х.Пэрлээ гуайн тоглоомын хөлгийг сэргээн зурсан зураг [Евтюхова 1965]



Зураг 9. Буга тоглоомын дэлхийд тархсан хувилбарууд. а. БНХАУ, Ляонин, Жианчан, Ляо улсын үеийн бунхан [Feng Yongqian, Deng Baoxie 1983], б. ӨМӨЗО, Тунляо, Хоулинхэ, Алтан улсын хот [Shao Qinglong 1984], с. Хэнан, Жүси уул [Henan 2014] д. Баяннуур, Хайрхан [Tong Yongsheng 2010] е. Юннан, Юүшү уул ф. Энэтхэг, Карнатака, Вижжаянагара [Elke Rogersdotter 2010]